БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# БӨМБӨГӨР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**АУДИТЫН КОД:** БНА-2021/89/СТА-ТШЗ

Баянхонгор
2021 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээнэям

Утас: 88011833 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

“Баянташаагийн эх аудит” ХХК-ний аудитор: Т.Хоролсүрэн

Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com

Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/ ..... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 8
3.Аудитын тайлан ..... 9
3.1. Ерөнхий зүйл ..... 9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ..... 10
3.4. Материаллаг байдал ..... 10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ..... 12
3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 13
3.9. Аудитын илрүүлэлт ..... 13
Залруулсан алдаа ..... 13
Аудитын зөвлөмж ..... 13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ..... 13
4. Менежментийн захидал ..... 14
5. Хавсралт Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 15



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.02.25 № 2/154

танай ____________ -ны №____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН
БӨМБӨГӨР СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Д.ОЮУНДАЛАЙ ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.
Тус Эрүүл мэндийн төв нь Бөмбөгөр сумын Засаг дарга, Аймгийн Эрүүл мэндийн газартай хамтарсан гэрээ байгуулан ажиллаж, сүүлийн хагас жилийн гэрээ 96,5 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Аудитын хүрээнд бусад асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

2021 А4 ТООТ

005020153

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **14,865,352.08** | **23,544,992.13** |
| **33** | **АВЛАГА** | 535,855.08 | 641,522.95 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 535,855.08 | 641,522.95 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 400,000.00 | 00.00 |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 400,000.00 | 00.00 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 400,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 13,929,497.00 | 22,903,469.18 |
| **351** | **Түүхий эд материал** | 10,593,183.00 | 13,445,539.18 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 9,715,378.00 | 9,532,767.00 |
| 35130 | Эм боох материал | 877,805.00 | 3,912,772.18 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 1,109,000.00 | 00.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 2,227,314.00 | 9,457,930.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 162,000.00 | 22,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,950,010.00 | 2,340,070.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 82,204.00 | 834,860.00 |
| 35460 | Хүнсний материал | 33,100.00 | 115,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 00.00 | 6,145,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **367,397,077.41** | **384,411,352.25** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 367,397,077.41 | 384,411,352.25 |
| **392** | **Биет хөрөнгө** | 356,911,077.21 | 373,925,352.25 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 285,841,456.00 | 336,053,921.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -17,373,384.11 | -31,799,381.63 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 45,360,000.00 | 31,360,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -5,560,010.44 | -7,839,999.96 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 95,057,887.92 | 95,057,887.92 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -65,363,945.87 | -74,074,327.21 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 24,438,155.00 | 33,971,155.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -6,034,581.29 | -9,349,402.87 |
| 39217 | Ном | 545,500.00 | 545,500.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 10,486,000.20 | 10,486,000.00 |
| 39301 | Програм хангамж | 650,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -649,999.80 | -450,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 10,486,000.00 | 10,486,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **382,262,429.49** | **407,956,344.38** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **19,479.00** | **5,507,201.16** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 19,479.00 | 5,507,201.16 |
| **413** | **Өглөг** | 19,479.00 | 5,507,201.16 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 19,479.00 | 3,946,301.16 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 1,560,900.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **382,242,950.49** | **402,449,143.22** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 382,242,950.49 | 402,449,143.22 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 326,681,036.00 | 326,681,036.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 326,681,036.00 | 326,681,036.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -76,221,032.15 | -56,014,839.42 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -76,221,032.15 | -76,221,032.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 20,206,192.73 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 131,782,946.64 | 131,782,946.64 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **382,262,429.49** | **407,956,344.38** |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **433,316,100.00** | **544,633,773.40** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **185,000.00** | **69,057,431.40** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 185,000.00 | 69,057,431.40 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 185,000.00 | 69,057,431.40 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 185,000.00 | 69,057,431.40 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **433,131,100.00** | **475,576,342.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 379,864,100.00 | 372,847,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 379,864,100.00 | 372,847,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 79,100.00 | 44,363,882.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 79,100.00 | 44,363,882.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 20,532,800.00 | 25,552,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,532,800.00 | 25,552,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 32,655,100.00 | 32,812,460.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 32,655,100.00 | 32,812,460.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **437,142,768.81** | **506,629,746.11** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **437,142,768.81** | **506,629,746.11** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 437,135,736.46 | 481,853,440.67 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 263,811,403.83 | 299,276,777.34 |
| 210101 | Үндсэн цалин | 263,811,403.83 | 297,613,268.34 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 1,663,509.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34,315,399.64 | 38,053,346.51 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,352,526.02 | 26,030,644.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,288,193.58 | 3,051,768.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,444,075.52 | 2,424,613.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 600,678.71 | 595,121.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,629,925.81 | 5,951,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,541,516.00 | 24,030,867.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,025,116.00 | 2,230,507.00 |
| 210302 | Түлш, халаалт | 14,378,400.00 | 21,400,360.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 138,000.00 | 400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,433,462.00 | 24,236,680.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,270,050.00 | 5,453,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,284,556.00 | 16,389,904.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,815,000.00 | 2,016,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 33,800.00 | 286,140.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 30,056.00 | 90,886.00 |
| **2105** | **Норматив зардал** | 37,870,644.65 | 37,653,859.22 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 26,285,644.65 | 29,293,069.22 |
| 210502 | Хоол, хүнс | 8,276,000.00 | 7,105,790.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,309,000.00 | 1,255,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,152,700.00 | 6,980,550.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,152,700.00 | 6,980,550.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,820,000.00 | 1,472,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,820,000.00 | 1,472,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,578,145.00 | 4,419,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,578,145.00 | 3,569,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 850,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 44,612,465.34 | 45,728,860.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,136,464.00 | 11,437,660.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 20,476,001.34 | 34,291,200.60 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7,032.35 | 24,776,305.44 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 19,101,882.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 19,101,882.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 3,418.00 | 1,569,073.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,418.00 | 1,569,073.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,614.35 | 4,105,350.44 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,614.35 | 4,105,350.44 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-3,826,668.81** | **38,004,027.29** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 215,989.86 | 17,797,834.56 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 215,989.86 | 8,439,989.56 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 9,357,845.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -215,989.86 | -17,797,834.56 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-4,042,658.67** | **20,206,192.73** |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **433,131,100.00** | **475,576,342.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **433,131,100.00** | **475,576,342.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 379,864,100.00 | 372,847,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 379,864,100.00 | 372,847,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 79,100.00 | 44,363,882.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 79,100.00 | 44,363,882.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 20,532,800.00 | 25,552,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,532,800.00 | 25,552,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 32,655,100.00 | 32,812,460.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 32,655,100.00 | 32,812,460.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **411,293,300.00** | **466,043,342.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **411,293,300.00** | **466,043,342.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **411,286,267.65** | **441,267,036.56** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 260,711,900.00 | 280,184,729.56 |
| 210101 | Үндсэн цалин | 195,628,200.00 | 201,937,100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 51,019,500.00 | 58,929,792.30 |
| 210104 | Урамшуулал | 14,064,200.00 | 19,317,837.26 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,882,800.00 | 35,850,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,527,500.00 | 24,519,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,588,800.00 | 2,832,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,071,100.00 | 2,266,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 517,800.00 | 566,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,177,600.00 | 5,665,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,529,382.00 | 22,985,027.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,729,862.00 | 2,731,827.00 |
| 210302 | Түлш, халаалт | 14,399,520.00 | 19,853,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000.00 | 400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,979,240.00 | 21,679,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,199,500.00 | 1,198,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,765,100.00 | 15,515,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,015,000.00 | 2,016,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,999,640.00 | 2,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 950,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 38,763,105.65 | 19,890,690.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 27,048,505.65 | 11,081,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,699,600.00 | 6,299,190.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,015,000.00 | 2,510,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,000,000.00 | 4,010,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 1,180,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 2,830,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,820,000.00 | 1,472,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,820,000.00 | 1,472,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,879,106.00 | 41,507,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14,479,106.00 | 40,657,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 850,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18,720,734.00 | 13,685,590.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,720,734.00 | 13,685,590.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,032.35** | **24,776,305.44** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 19,101,882.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 19,101,882.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 3,418.00 | 1,569,073.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,418.00 | 1,569,073.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,614.35 | 4,105,350.44 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,614.35 | 4,105,350.44 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **21,837,800.00** | **9,533,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **21,837,800.00** | **9,533,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **21,837,800.00** | **9,533,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 21,837,800.00 | 9,533,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 21,837,800.00 | 9,533,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-21,837,800.00** | **-9,533,000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 316,195,036.00 | 56,224,214.00 | -61,686,867.00 | 00.00 | 310,732,383.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **316,195,036.00** | **56,224,214.00** | **-61,686,867.00** | **00.00** | 310,732,383.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -8,943,877.14 | 00.00 | -8,943,877.14 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **326,681,036.00** | **131,782,946.64** | **-76,221,032.15** | **00.00** | 382,242,950.49 |
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **326,681,036.00** | **131,782,946.64** | **-76,221,032.15** | **00.00** | 382,242,950.49 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **326,681,036.00** | **131,782,946.64** | **-76,221,032.15** | **00.00** | 382,242,950.49 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 20,206,192.73 | 00.00 | 20,206,192.73 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **326,681,036.00** | **131,782,946.64** | **-56,014,839.42** | **00.00** | 402,449,143.22 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | дүн | хувь |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 431,243,000.00 | 425,538,036.56 | (5,704,963.44) | 98.68 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 431,243,000.00 | 425,538,036.56 | (5,704,963.44) | 98.68 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 431,243,000.00 | 425,538,036.56 | (5,704,963.44) | 98.68 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 282,849,000.00 | 280,184,729.56 | (2,664,270.44) | 99.06 |
| 210101 | Үндсэн цалин | 201,937,100.00 | 201,937,100.00 | - | 100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 60,718,200.00 | 58,929,792.30 | (1,788,407.70) | 97.05 |
| 210104 | Урамшуулал | 20,193,700.00 | 19,317,837.26 | (875,862.74) | 95.66 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,850,800.00 | 35,850,800.00 | - | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,519,200.00 | 24,519,200.00 | - | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,832,900.00 | 2,832,900.00 | - | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,266,300.00 | 2,266,300.00 | - | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 566,600.00 | 566,600.00 | - | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,665,800.00 | 5,665,800.00 | - | 100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,552,800.00 | 22,985,027.00 | (1,567,773.00) | 93.61 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,732,800.00 | 2,731,827.00 | (973.00) | 99.96 |
| 210302 | Түлш, халаалт | 21,420,000.00 | 19,853,200.00 | (1,566,800.00) | 92.69 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000.00 | 400,000.00 | - | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,681,100.00 | 21,679,600.00 | (1,500.00) | 99.99 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 1,198,500.00 | (1,500.00) | 99.88 |
| 210402 | Түлш, шатахуун | 15,515,100.00 | 15,515,100.00 | - | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,016,000.00 | 2,016,000.00 | - | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 950,000.00 | 950,000.00 | - | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 19,891,800.00 | 19,890,690.00 | (1,110.00) | 99.99 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 11,081,800.00 | 11,081,500.00 | (300.00) | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,300,000.00 | 6,299,190.00 | (810.00) | 99.99 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,510,000.00 | 2,510,000.00 | - | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,682,900.00 | 8,680,400.00 | (2,500.00) | 99.97 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,850,000.00 | 5,849,700.00 | (300.00) | 99.99 |
| 210604 | Урсгал засвар | 2,832,900.00 | 2,830,700.00 | (2,200.00) | 99.92 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,657,200.00 | 1,472,800.00 | (184,400.00) | 88.87 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,657,200.00 | 1,472,800.00 | (184,400.00) | 88.87 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 20,233,800.00 | 18,950,800.00 | (1,283,000.00) | 93.66 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 19,383,800.00 | 18,100,800.00 | (1,283,000.00) | 93.38 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 850,000.00 | 850,000.00 | - | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15843600.00 | 15843190.00 | (410.00) | 100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,843,600.00 | 15,843,190.00 | (410.00) | 100.00 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | дүн | хувь |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 431,243,000.00 | 425,538,036.56 | (5,704,963.44) | 98.68 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 372,847,200.00 | 372,844,099.56 | (3,100.44) | 100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 372,847,200.00 | 372,844,099.56 | (3,100.44) | 100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 25,552,800.00 | 23,983,727.00 | (1,569,073.00) | 93.86 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 25,552,800.00 | 23,983,727.00 | (1,569,073.00) | 93.86 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 32,843,000.00 | 28,710,210.00 | (4,132,790.00) | 87.42 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 32,843,000.00 | 28,710,210.00 | (4,132,790.00) | 87.42 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 | - | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 | - | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 24.00 | 24.00 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 18.00 | 18.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05.00 | 05.00 | - | 100.00 |
| **64** | **ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО** | 215.00 | 215.00 | - | 100.00 |
| 640001 | Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо | 215.00 | 215.00 | - | 100.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **24.00** | **24.00** | - | 100.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 16.00 | 16.00 | - | 100.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 08.00 | 08.00 | - | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **44,363,882.00** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **44,363,882.00** | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 44,363,882.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **25,262,000.00** | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 25,262,000.00 | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **0.00** | **19,101,882.00** | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **19,101,882.00** | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 19,101,882.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **0.00** | **44363882.00** | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **44,363,882.00** | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 44,363,882.00 | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | |

# 3.Аудитын тайлан

## 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Эрүүл мэндийн төвийн дарга Д.Оюундалай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 27-ээс 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд “Баянташаагийн эх аудит” ХХК-ний аудитор Т.Хоролсүрэн Ч.Чимгээ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Тус Эрүүл мэндийн төв нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг “ Баянташаагийн эх аудит” ХХК-д 2021 оны 01 сарын 15 өдрийн 24 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв нь “эрхэм зорилгоо орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэн нотолгоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөжүүлснээр хүн амд ээлтэй тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг үзүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль

## 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 437142,7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8742.9 мянган



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 506629,7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10132.6 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх гол үзүүлэлтүүдийг өмнөх онтой зэрэгцүүлэн судлахад өмнөх оноос бараа материал, авлага, өглөг болон үндсэн хөрөнгийн данс нэмэгдсэн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 14,865.4 | 23,545.0 | 8,679.6 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 535.9 | 641.5 | 105.7 |
| Урьдчилгаа | 400.0 | - | (400.0) |
| Бараа материал | 13,929.5 | 22,903.5 | 8,974.0 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 367,397.1 | 384,411.4 | 17,014.3 |
| Үндсэн хөрөнгө | 462,379.0 | 507,924.5 | 45,545.5 |
| Хуримтлагдсан элэгдэл | (94,981.9) | (123,513.1) | (28,531.2) |
| **Нийт хөрөнгө** | 382,262.4 | 407,956.3 | 25,693.9 |
| Өр төлбөр | 19.5 | 5,507.2 | 5,487.7 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 382,243.0 | 402,449.1 | 20,206.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 382,262.4 | 407,956.3 | 25,693.9 |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 22903,5 мянган төгрөг болж 8974,0 мянган төгрөгөөр өссөн нь цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, эм боох материалын болон шатахууны нөөц бүрдүүлсэнтэй холбоотой байна.

Аймгийн Эрүүл мэндийн газраас 10565,2 мянган төгрөгийн тендерийн эм, боох материал авснаас 8893,2 мянган төгрөгийг эмнэлэгт зарцуулж, 1672,0 мянган төгрөгийн тендерийн эмийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 507924,5 мянган төгрөг болж 45545,5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 40221,8 мянган төгрөгөөр Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл сайжруулалт, 9533,0 мянган төгрөгөөр тавилга эд хогшил худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 402449,1 мянган төгрөг болж 20206,2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 544633,8 мянган төгрөг болж, өмнөх оноос 111317,7 мянган төгрөгөөр буюу 25,7 хувиар өссөн байна.

Өмнөх оноос тусламж санхүүжилтийн орлого 42445,2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 7016,9 мянган төгрөгөөр буурч, нэмэлт санхүүжилтийн орлого 44284,8 мянган, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 5020,0 мянган, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 157,4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал 506629,8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 69486,9 мянган төгрөгөөр буюу 15,9 хувиар өссөн байна. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 35465,4 мянган, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 3738,0 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 7489,4 мянган, урсгал засварын болон багаж техник хэрэгсэл



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

худалдан авах зардал 5827,9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, хангамж бараа материалын зардал 4196,8 мянган норматив зардал 216,7 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн бараа үйлчилгээний зардал 4158,2 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд салбарын онцлогийг тусгасан сумын хүн амын болон багийн тоо, үйлчилгээний радиус, аймгийн төвөөс алслалтыг төлөвлөснөөс гадна цалингийн зардалд 254172,4 мянган, тогтмол зардал 25552,8 мянган, урсгал зардалд 8500,0 мянган, тэтгэвэрт гарах 3 хүний тэтгэмж 43142,4 мянган, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 2 ажилтны тэтгэмж 7942,2 мянган төгрөгийг төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тухайн онд төсвийг анх 387592,9 мянган төгрөгөөр баталсан байснаа 2 удаа тодотгол хийж, 383813,0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 431243,0 мянган төгрөгийн төсөв баталснаас 372847,2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 25552,8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 32843,0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 372847,2 мянган, орон нутгийн төсвөөс 25552,8 мянган, эрүүл мэндийн даатгалын сангаас 32812,4 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 431212,4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсвөөс 5674,4 мянган төгрөг дутуу зарцуулсан нь түлш халаалтын зардлын 1569,0 мянган төгрөгийн гүйлгээ оны эцэст төрийн сангийн төлбөр тооцоо, гүйлгээ хаах өдөр буцаж орж ирээд тэр хэмжээгээр өртэй гарч орон нутгийн төсөвт төвлөрсөн. 4135,2 мянган төгрөгийн Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт мөн төрийн сангийн төлбөр тооцоо, гүйлгээ хаагдах өдөр орж ирснээс гүйлгээ бүрэн хийгдэлгүй НДШ-ийн өртэй гарсан байна.

Нийт төсөвт зардлын гүйцэтгэлийг хөтөлбөр арга хэмжээний зардлын гүйцэтгэлээр авч үзвэл үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээний зардал 4104,6 мянган, байр ашиглалтын зардал 1569,0 мянган төгрөгөөр тус тус ашиглагдаагүй харагдаж байгаа боловч тэр хэмжээгээрээ өртэй гарсан байна.

*Хүснэгт 2.* Хөтөлбөр, арга хэмжээний зардлын гүйцэтгэл /мянган.төгрөгөөр/

| Д/Д | Хөтөлбөр, арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| 1 | 71602,0 | Эмнэлгийн тусламж, үйлчилгээ | 431243,0 | 425538.1 | (5704.9) | 100,0 |
| 1.1 | 81603 | Үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ | 379834,1 | 375698.9 | (4135.2) | 100,0 |
| 1.2 | 80109 | Байр ашиглалтын үйлчилгээ | 25552,8 | 23983,8 | (1569,0) | 99,9 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.3 | 80302 | Нэг хүнд ноогдох нормативт зардал | 25856,1 | 25855,4 | (0,7) | 100,0 |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны төсвийн хэлбэлзлийн тайлан*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 44363,8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсний хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлсэн дэмжлэг 19101.8 мянган, Аймгийн ЭМГ-ын даргын 2020 оны А/133 тоот тушаалын дагуу тайлант онд үүссэн өр барагдуулахад зориулж 25262.0 мянган төгрөг бүрдсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 5 ажиллагсдад 19082,1 мянган төгрөгийн дэмжлэг олгож, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгт 14517,0 мянган, Эм, эмнэлгийн хэрэгслийн өрөнд 8875,3 төгрөгийг шилжүүлж, бараа үйлчилгээний өглөгт 1850,0 мянган, сорьц тээвэрлэлтийн зардалд19,7 мянган төгрөгийг өгсөн байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 27 төрлийн 151 мэдээлэл оруулахаас 146 мэдээллийг хугацаанд байршуулж, төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, худалдан авах ажиллагааны тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гэсэн 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

*Хүснэгт 3.* Шилэн дансны мэдээлэл

| Д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд нь оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 93 | 3 | |
| | Нийт | 27 | 151 | 146 | 3 | 2 |

*Эх сурвалж:* www.shilendans.gov.mn цахим хуудас

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2020 оны 05 дугаар сарын 21-өдрийн 36 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл хоцроож байршуулсан зөрчил илэрснийг давтан гаргахгүй байх талаар 1 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Санхүүгийн тайлангаар залруулсан алдаа байхгүй.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд тусгасан, бусад хэлбэрээр шийдсэн алдаа зөрчилтэй асуудал илэрсэнгүй.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Аймгийн хэмжээнд нэгдсэн журмаар эмийн тендерийн асуудлыг аймгийн ЭМГ нь зохион байгуулж, үнэгүй эм болон хамгаалах хэрэгсэл олгож байгаатай холбогдуулан эмийн ханган нийлүүлэлтийн асуудлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай ба тус байгууллагад аймгийн ЭМГ-с тайлант онд олгосон тендерийн 10565,1 мянган төгрөгийн эмээс 1769,8 мянган төгрөгийн эм сумын эмийн эргэлтийн санд үлдэгдлээр байгаа нь тухайн байгууллагын дансанд тусгагдсан болно.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

***1.* Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхтэй *холбоотой асуудал***

*1.1 Илрүүлэлт:* 27 төрлийн 151 мэдээлэл оруулахаас 146 мэдээллийг хугацаанд байршуулж, төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, худалдан авах ажиллагааны тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гэсэн 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

*1.2. Эрсдэл*: Мэдээллийн ил тод байдал

1.3 *Өгсөн зөвлөмж*: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсний дагуу мэдээллийг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тухайн удирдлага нарт талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР — Ч.ЧИМГЭЭ
Огноо: 2021.02.25

Анхан шатанд хянасан:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР — А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.25



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ

## 5. Хавсралт Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021 | | | БНА-2021/89/СТА-ТШЗ |
| **Шалгагдсан байгууллагын нэр:** | | Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шилэн дансны сайтад 27 төрлийн 151 мэдээлэл оруулахаас 146 мэдээллийг хугацаанд байршуулж, төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, худалдан авах ажиллагааны тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гэсэн 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. | 0 | Зөвлөмж өгөх | Эрхлэгч, нягтлан бодогч | Д.Оюундалай Ж.Гандалай |
| **ДҮН** | | **0** | | | |

----oOo----